

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 10

Тус газар нь нийгмийн даатгалын шимтгэлийн сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоон олгож, ажил олгогч, даатгуулагч иргэдэд хөнгөн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх, дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн үр дүнг дээшлүүлэх, мэдээллийн систем хөгжүүлэх төслийн хүрээнд ажилтан, албан хаагчдыг сургах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргийн ажлыг гүйцэтгэхийн зэрэгцээ ажилтан, албан хаагчдын ар гэр болон тэдгээрийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, нөхөрсөг харилцааг бий болгоход зохион байгуулж буй нийтийн арга хэмжээнүүдэд хамт олныг идэвхтэй хамруулж, нийгмийн баталгааг хангах зэрэг ажлыг хэрэгжүүлэн ажиллалаа.

Түүнчлэн Нийгмийн даатгалын төв, орон нутгийн хэмжээнд 2024 оныг “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”, дүүргээс “Бүтээмж-Хамтын ажиллагааг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан баталж, төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд ажил үйлчилгээгээ төлөвлөн явуулж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаар

2024 оны нийгмийн даатгалын шимтгэлийн сангийн 3451.9 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөтэйгөөс албан журмын даатгуулагчаас 3062.4 сая төгрөгийг санд хуримтлуулсан ба 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр 389.5 сая төгрөгийн орлого бүрдүүлбэл орлогын төлөвлөгөөг 100 хувиар биелүүлэхээр байна.

Тайлант хугацаанд нийт 767 тэтгэвэр авагчдад 7.7 тэрбум төгрөгийг зарцуулсан. Зарцуулалтыг тэтгэврийн төрлөөр харуулбал:

- Өндөр насны 588 тэтгэвэр авагчдад 5471.2 сая төгрөгийг,
- Хөдөлмөрийн чадвар алдсаны 88 тэтгэвэр авагчдад 695.9 сая төгрөгийг,
- Тэжээгчээ алдсаны 34 тэтгэвэр авагчдад 502.9 сая төгрөгийг,
- Цэргийн 54 тэтгэвэр авагчдад 994.7 сая төгрөгийг
- ҮОМШ өвчний 4 тэтгэвэр авагчдад 54.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Мөн тэтгэвэр тогтоолгосноос хойш шимтгэл төлж ажилласан жилээ нэмэгдүүлэхээр 23 тэтгэвэр авагч хүсэлт ирүүлснээс 23 тэтгэвэр авагчийн ажилласан жилийг нэмэгдүүлэн тооцож, сард 612.9 мянган төгрөгөөр, 6 болон 7 жилийн цалингаар тэтгэврээ тооцон тогтоолгосон 113 тэтгэвэр авагч 5 жилээр өөрчлөн тогтоолгох хүсэлт гаргаснаас 95 тэтгэвэр авагчийн тэтгэвэр өөрчлөн тогтоогдож сард дундажаар 8.5 сая төгрөгөөр, 18 тэтгэвэр авагчийн тэтгэвэрт өөрчлөлт орж нэмэгдээгүй байна.

Нийгмийн даатгалын сангаас нийт 273 даатгуулагчид 4 төрлийн тэтгэмжид 548.7 сая төгрөгийг олгосон. Үүнээс:

- ХЧТА-ын тэтгэмжийг -131 даатгуулагчид- 25.0 сая төгрөг,

- Жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийг -74 даатгуулагчид-279.5сая төгрөг,
- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг-21 даатгуулагчид 42.0 сая төгрөг,
- Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж- 47 даатгуулагчид 202.2 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Засгийн газрын “Тэтгэвэр нэмэгдүүлэх тухай” 120 дугаар тогтоолоор 746 тэтгэвэр авагчдын тэтгэврийг 100000 төгрөгөөр нэмэгдүүлэн сардаа нийт 7.4 сая төгрөг зарцуулагджээ.

Сангийн төвлөрүүлэлт, хуваарилалтын талаар:

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар НДШ орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.1-д заасны дагуу төвлөрсөн харилцах дансны үлдэгдлийг өдөр бүр төвлөрүүлж, нийтдээ 3.8 тэрбум төгрөгийг төвлөрүүлэн журмын хэрэгжилтийг ханган ажилласан. Сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг доорх сангаас төвлөрүүлсэн. Үүнээс:

- Тэтгэмжийн даатгалын сан 20.0 сая төгрөг
- ҮОМШӨ даатгалын сан 10.0 сая төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сан 16.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

Нийт 6.1 тэрбум төгрөгийг сан хооронд хуваарилж, холбогдох сангуудаас гарах зардлыг иргэд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж олгож үйлчилгээ үзүүлсэн.

- Тэтгэврийн даатгалын санд- 5.4 тэрбум төгрөг
- Тэтгэмжийн даатгалын санд- 363.9 сая төгрөг
- ҮОМШӨ даатгалын санд- 117.7 сая төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын санд- 223.8 сая төгрөгийг тус тус хуваарилсан

Нийгмийн даатгалын хамралт, өр авлага барагдуулалтын талаар

Тайлант хугацаанд нийт 64 ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг сар бүр хүлээн авч баталгаажуулан, 17 ажил олгогчийн 166.6 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг үлдэгдлийн баталгаагаар тооцоо нийлэн ажилласан.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын хамралтыг нэмэгдүүлэх тухай тушаалаар:

- Ажил олгогч-67
- Нийгмийн даатгалын албан журмын даатгуулагч-1035,
- Сайн дурын даатгуулагч-144
- Малчин СДД-3
- Хөгжлийн бэрхшээлтэй СДД-15
- 0-3 насны хүүхэд асарч буй СДД-1 тус тус батлагдсанаас
- ✓ Ажил олгогч-64
- ✓ Нийгмийн даатгалын албан журмын даатгуулагч- 936,
- ✓ Сайн дурын даатгуулагч-120
- ✓ Малчин СДД -3
- ✓ Хөгжлийн бэрхшээлтэй СДД-15
- ✓ 0-3 насны хүүхэд асарч буй СДД-1 тус тус хамруулж нийт хамралт 88.3 хувийн биелэлттэй байна.

Зорилтот жил болгон зарласантай холбогдуулан хамралтыг нэмэгдүүлэхээр дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Засаг даргын Нийгмийн бодлогын хөгжлийн орлогчоор ахлуулсан Засаг даргын Тамгын газар болон бусад харьяалах 10 хэлтэс

албадын мэргэжилтнүүдийн хамт 2024 оны 4 дүгээр сарын 9,10-нд, 11 дүгээр сарын 6,7-ны өдрүүдэд дүүргийн шугам замын өртөө болон малчин өрхөд явуулын нэг цэгийн үйлчилгээгээр 4 удаа үйлчилж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдээ, мэдээлэл өгч ажилласан. Явуулын үйлчилгээнд нийт 30 өрхийн 97 иргэн хамрагдсан бөгөөд 9 иргэний тэтгэвэр тогтоолтын баримт бичгийг шалгаж, 5 өрхөд малчны сайн дурын даатгалын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, 5 төрлийн 160 гарын авлага тараан ажиллалаа. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 9 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласантай холбогдуулан тус газар нь 2024 оны 9 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд дүүргээс алслагдсан төмөр замын байгууллага болон малчин өрхүүдэд 3 байцаагч, мэргэжилтнүүд нийгмийн даатгалын үйлчилгээг ойртуулан ажлын байранд болон гэрт нь хүргэн ажилласан.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага бууруулах тухай” А/199 дүгээр тушаалаар авлагыг насжилтаар нь ангилан шат дараалсан арга хэмжээ авч ажиллалаа. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага үүсгэсэн 15 аж ахуйн нэгж байгууллагын 54.9 сая төгрөгийн өр авлагад албан шаардлага хүргүүлж, 44 сая төгрөг авлага барагдуулан, 16 байгууллагатай 73.7 сая төгрөгийн өр авлагатай ажил олгогчтой уулзалт зохион байгуулж 31.2 сая төгрөгийн авлага барагдуулан ажилласан.

Хуримтлагдсан өр авлага үүсгэсэн аж ахуйн нэгж, байгууллагын баримт бичгийн бүрдүүлбэрийг ханган 2 аж ахуйн нэгж байгууллагын 18.9 сая төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлсэн.

Төсөвт байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага үүсгэсэн судалгааг гаргаж дүүргийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээ байгуулан гэрээний дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн урсгал өр үүсгэсэн байгууллагатай уулзалт зохион байгуулан 30.1 сая төгрөгийг 2024 оны 9 дүгээр сард барагдуулан ажиллалаа.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээтэй өр авлага үүсгэсэн эрүүл мэндийн байгууллагын судалгааг Нийслэлийн Эрүүл мэндийн даатгалын газарт гарган хүргүүлж шимтгэлийн өр үүсгэсэн 1 байгууллагын 3.8 сая төгрөгийг барагдуулсан.

2024 оны эхний 140.1 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 43.2 сая төгрөгийг буюу 30.8 хувиар бууруулсан байна.

Одоогийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн 17 ажил олгогчийн 166.6 төгрөгийн авлагын 55.1 сая төгрөг нь Төмөр замын 2 байгууллагын урсгал авлага, 2 ажил олгогчийн 18.9 сая төгрөгийн авлагыг шүүхэд хандсан, 3 ажил олгогчийн 63.5 сая төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт албадан гүйцэтгүүлэхээр шилжүүлсэн, бусад 29.1 сая төгрөгийн авлагыг байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийж, тэмдэглэл хөтлөн даруй барагдуулахаар шийдвэрлэсэн бөгөөд төсвийн байгууллага нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлагагүй байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээ 18.0 хувьтай байна.

Төсөв, санхүү, мэдээллийн ил тод байдал, дотоодын болон бусад хяналт шалгалтын талаар

Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн

даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тушаал шийдвэр, Нийгмийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн тогтоол зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалын сангийн 8.0 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 7.7 тэрбум төгрөгийг, (12 сарын байдлаар) тэтгэмжийн даатгалын төсөв 363.5 сая төгрөгөөс 548.7.0 сая (2024.12.10-ны байдлаар) төгрөг зарцуулагджээ. Тэтгэвэрийн даатгалын зарцуулалт 300.0 сая төгрөгөөр хэмнэгдсэн, жирэмсэн амаржсаны тэтгэмжийн даатгалын зарцуулалт 68.2 төгрөгөөр хэтэрсэн бусад зардал төлөвлөгөөний дагуу зарцуулагдсан байна.

Үйл ажиллагааны 292.0 сая төгрөгийн санхүүжилттэйгээс цалинд 199.9 сая төгрөг, НДШ-д 24.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардал 4.2 сая төгрөг, хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад 11.2 сая төгрөг гэх мэт 11 төрлийн зардлыг зарцуулсан.

Төсвийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хууль, ЗГ-ын тогтоолын дагуу төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж, үйл ажиллагааны батлагдсан төсвийн зардлыг 10-аас доошгүй хувиар хэмнэнэ гэж заасны дагуу 29.2 сая төгрөгийг хэмнэсэн байна.

Газрын даргын дотоод хяналт шалгалт хийх тухай журмын дагуу тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголтод хяналт шалгалт хийхэд тэтгэвэрт 2.3 сая төгрөгийг, тэтгэмжид 1.3 сая, ажилгүйдэл 6.0 сая төгрөгийг тус тус илүү олгосон зөрчил илэрсэн. Шинэээр үүссэн зөрчлөөс 6.7 сая төгрөгийг, өмнөх оны 6.5 сая төгрөгийн зөрчлөөс 0.9 мянган төгрөгийг тус тус барагдуулсан байна.

Нийслэлийн аудитын газар, “Өлзийт экаунт” ХХК аудитын байгууллагатай гурвалсан гэрээ байгуулж 2023 оны ажлаа шалгуулж, 2 зөвлөмж, 3 албан шаардлагатай, зөрчилгүй дүгнэгдсэн. Албан шаардлага, зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулж, биелэлтийг 2024.06.30-нд өгсөн. НДЕГ-ын Хяналт шалгалтын газар 2021-2023 оны ҮОМШӨ-ний даатгалын санд хяналт шалгалтыг 4 дүгээр сард хийсэн бөгөөд зөрчил илрээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн дагуу санхүүгийн 169, сангийн 171, хүний нөөцийн 55 мэдээллийг цахим системд мэдээллэсэн ба байгууллагын вэб хуудсанд 10 заалтын 38 арга хэмжээг байршуулан НДЕГ-ын ДАМГ-аас хяналт шалгалтыг хийж, хагас жилээр 57.8 хувьтай үнэлэгдсэн. Жилийн эцсээр хяналт шалгалт хийгдсэн бөгөөд эцсийн үнэлгээ гараагүй байна.

Иргэдэд мэдээллийг нээлттэй, ил тод хүргэхэд төсөв, үйл ажиллагааны тайлан, ажлын байрны сул орон тооны зар, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээ зэргийг мэдээллийн самбарт, байгууллагын фэйсбүүк хуудсанд нээлттэй байршуулж, ХХҮХ, ЗДТГ-ын хэвлэл, мэдээллээр дамжуулан нээлттэйгээр хүргүүлэн ажилласан.

Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, тооллогын талаар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны “Маягт батлах тухай” 323 дугаар тогтоолоор баталсан төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг захиргааны статистикийн маягтын дагуу эд хөрөнгийн бүртгэл, тайланг цахим системд 2024 онд бүртгэсэн.


Газрын даргын А/09 тоот тушаалын дагуу Өмч хамгааллын байнгын зөвлөл, өмч хөрөнгийн тооллогоор 102.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдож, ашиглах

боломжгүй, ашиглах хугацаа дууссан, дутагдсан, нэмэгдсэн хөрөнгийн бүртгэлийг ТӨ, ТӨХ маягтын дагуу бүртгэлийг хийж байна. 2024 онд ашиглах хугацаа дууссан.

- Тавилга эд хогшил 6.4 сая төгрөг,
- Машин тоног төхөөрөмж 1.2 сая төгрөг нийт 14 хөрөнгийн 7.6 сая төгрөгийн актлах хөрөнгийн жагсаалтыг НДЕГ-т хүргүүлсэн, үүнээс 6 хөрөнгийн ашиглах хугацаа сунгах, дахин үнэлэх хүсэлт явуулсан байна.

Эд хөрөнгийн жилийн эцсийн тооллого явуулах бэлтгэл ажил хангагдсан 2024.12.25-ны дотор хийж дуусгахаар хугацаатай байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлж Жи Эн Топ линк ХХК-тай гэрээ байгуулан дотор үйлчилгээний зааланд 1 ширхэг, барилгын гадна орчны 3 талыг харуулсан 3 ширхэг камержуулалт, цонх, хаалганд дохиоллын систем, өрөөнүүдэд ус, утаа мэдрэгч зэргийг суурилуулж, барилга байгууламж, эд хөрөнгийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны талаар

Тус газар нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын А/52 дугаар тушаалаар баталсан 6 хүний бүтэц орон тоотой ажиллаж байна. Ажлын байрны ТЗ-ны 2, ТҮ-ний 1 албан тушаалын сул орон тоо гарсан бөгөөд ТҮ-ний орон тоог нөхөхөөр ЗДТГ-ын хэвлэл мэдээллээр, ХХҮХ-т ажлын зар хүргүүлсэн.

Төрийн жинхэнэ албан хаагчийг нээлттэй зарлаж сонгон шалгаруулж, төрийн албаны санал болгох 10 дугаар тогтоолын дагуу Газрын даргын Б/21 дүгээр тушаалаар 1 албан хаагчийг албан тушаалд томилсон. Төрийн жинхэнэ албан хаагчийг нөхөх зараар 1 сул орон тоо нөхөгдөөгүй тул ерөнхий шалгалтанд тэнцсэн албан тушаалын шаардлагыг хангасан иргэнийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллуулж байна.

Газрын даргын боловсон хүчний 30, үйл ажиллагаатай 19 захирамжлалын баримт бичгийг хууль зүйн үндэслэлтэй боловсруулан гаргасан.

Тайлант хугацаанд иргэнээс 18 хүсэлтийг хүлээн авч холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь хуулийн хүрээнд шийдвэрлэж 2 өргөдлийн хариуг албан бичгээр шуудангаар, бусад хариуг утсаар хүргүүлсэн, шийдвэрлэгдээгүй өргөдөл байхгүй, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 10 хоног байна.

Албан хэрэг хөтлөлтийн ер цахим системээр 192, able програмаар 205 албан бичиг ирснийг хүлээн авч бүртгэл хөтлөн газрын даргад танилцуулан хариутай 150 албан бичгийг холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь шийдвэрлүүлэн холбогдох газарт хүргүүлэн бусад байгууллагуудад 91 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан хүргүүлж ажилласан.

Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлсэн иргэдэд нийгмийн даатгалын лавлагаа цахим мэдээллийн сангаас:

- QR кодтой-87,

- Архивын цаасан баримтаас гараар шивсэн-24,

- Харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын хүсэлтийн дагуу 20 лавлагааг гарган өгч, иргэд, даатгуулагчдын хүсэлтээр тэдэнд чирэгдэлгүй шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор харьяа бусад газар луу хүсэлт илгээж 41лавлагааг гаргуулан дотоод сүлжээгээр дамжуулан авч даатгуулагчдын тэтгэврийг хугацаа алдалгүй тогтоож ажилласан. Жилийн хугацаанд 172 иргэнд лавлагаа мэдээлэл гаргаж өгсөн.

2024 оны архивын хөтлөх хэргийн жагсаалтын дагуу 80 хадгаламжийн нэгжийг албан хаагчдаас хуваарийн дагуу хүлээн авсан ба албан хаагчдад 41 баримтыг бүртгэл хөтлөн ашиглуулж ажилласан бөгөөд байгууллагын архивт:



➤ Байнга хадгалах-223

➤ 70 жил хадгалах- 357

➤ Түр хадгалах- 339 нийт 919 баримт хадгалалтын горимын дагуу хадгалагдаж байна.

Тайлант хугацааны 1 дүгээр улиралд 3 албан хаагчаас 80 боть архивын баримт, зогсоогдсон 30 хувийн хэрэг хүлээн авч стандартын дагуу бүртгэж архивласан. Мөн байгууллагын Баримт нягтлан шалгах комисс хуралдаж, хөтлөх нэрийн үлгэрчилсэн 101 төрлийн, үүнээс байнга-39, 70 жил-12, түр-50 жагсаалтыг боловсруулан газрын даргаар батлуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2015 оны “Байгууллагын архивын үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага, хадгалалтын горимыг тогтоож мөрдүүлэх журам” А/172 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд архивын нягтруулсан шүүгээтэй болох ажлыг зохион байгуулж баримтын хадгалалт, хамгаалалтын стандартыг ханган ажиллалаа.



2024 оны 12 дугаар сарын 10-ны байдлаар дээд газрын 77 тогтоол, шийдвэр ирснийг албан хаагчдад танилцуулан, хэрэгжилтийг ханган ажилласан. Тогтоол шийдвэрийг төрөлжүүлбэл:

-Засгийн газрын тогтоол- 3

-Монгол Улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал - 9

-Монгол Улсын сангийн сайдын тушаал-1

-МУ-н Соёл, спорт аялал жуулчлал залуучуудын яамны төрийн нарийн бичгийн даргын тушаал 1

-Улсын ерөнхий прокурор хууль зүй, Дотоод хэргийн сайдын хамтарсан тушаал-1

- НЗД-ын захирамж-4

- БХДЗД-ын захирамж-19
- Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол-1
- НДЕГ-ын даргын тушаал-36
- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал-1
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын тушаал-1
- Багахангай дүүргийн онцгой комиссын даргын тушаал-1


зэрэг 77 тогтоол шийдвэр ирсэн бөгөөд 49 тогтоол шийдвэрийн гүйцэтгэлийг ханган, бусад шийдвэрүүдийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, тогтоол шийдвэрийн биелэлтийг гарган НДЕГ-ын ЗУГ-т хүргүүлсэн.



Сургалт сурталчилгааны талаар:

-Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр:


Танхим болон цахимаар нийгмийн даатгалын байгууллагын шинээр нэвтрүүлсэн sigos цахим системтэй холбоотой 11 удаагийн сургалтанд 3 албан хаагч, бүх албан хаагчид монгол бичгийн 5 удаагийн, жендэрийн тэгш харилцаа, тэтгэвэр, тэтгэмжийн талаар гадаад орны туршлага солилцох сургалтад 1 албан хаагч, архив албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 2 удаагийн сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдаж мэдлэгээ дээшлүүлсэн байна.

Дүүргийн Соёлын Ордонд зохион байгуулсан “Угийн бичиг-цахим орчинд” сургалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас зохион байгуулсан “Үндсэн хуулийн агуулга мөн чанар” сэдэвт сургалт, Цагдаагийн хэлтсээс зохион байгуулсан “Цахим гэмт хэргээс сэргийлэх” сургалтад, Засаг Даргын Тамгын Газар, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комисс хамтран зохион байгуулсан “Хүний Эрхийн Төлөө Хамтдаа” нээлттэй өдөрлөгт Сургалт сурталчилгаа, архив, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн хамрагдаж сургалтын мэдээллээс албан хаагчдад хүргэн, ном товхимолтай танилцаж, мэдээлэл солилцон алба хаагчдад хүргэн ажиллалаа.







Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс зохион байгуулсан сэтгэл зүйч Г.Наранбаатарын “Сэтгэл зүйн эрүүл мэнд” сургалтад 3 албан хаагч хамрагдаж стресс тайлах аргуудаас суралцаж, байгууллагадаа хэрэгжүүлэн ажиллаж байна.



Онцгой байдлын ерөнхий газраас Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон яамны харьяа агентлаг, нэгжүүдэд Гамшгаас хамгаалах “Команд штабын сургууль” сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 11-ний 05⁰⁰ цагт зарлан мэдээлэх дохиогоор эхэлж, тус газрын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн, 3 байгууллагаас бүрдсэн гамшгаас хамгаалах штабын алба хаагчид 2 өдрийн хугацаанд идэвхтэй хамрагдаж өндөрлөлөө. Сургалтын явцыг ОБЕГ-аас хяналт тавьж ажиллан яамны хэмжээнд “Онц” үнэлгээ өгсөн бөгөөд дүүргийн Онцгой байдлын хэлтэс, хэлтсийн Орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын ахлах байцаагч дэд хурандаа Г.Ганзориг мэргэжлийн туслалцаа үзүүлэн хамтран ажиллалаа.



Байгууллага дотооддоо 4 ажилтан, албан хаагчдад нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн сургалтыг 2 удаа, байгууллагын ЭБАТ авилга, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 1 удаа, архив, албан хэрэг хөтлөлтийн сургалтыг 1 удаа тус тус зохион байгуулсан. Шинээр томилогдсон 1 албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг танилцуулж, нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн мэдээлэл өгч, уншиж судлах ном, гарын авлагаар хангаж ажиллав.




-Ажил олгогч болон иргэд даатгуулагчдад хууль сурталчлах чиглэлээр:



Дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг Багахангай тохижилт ОНӨААТҮГ, Илч орд ОНӨААТҮГ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ, Төмөр замын БЗАУАнги, 12-р хэсэг, 44-р цэцэрлэг зэрэг 6 ажил олгогч байгууллагын 163 даатгуулагчдад шинэчилсэн хуулийн сургалтыг, Засаг даргын Тамгын газар болон бусад харьяалах 10 хэлтэс албадын мэргэжилтнүүдийн хамт дүүргийн шугам замын өртөө болон малчин өрхөд явуулын нэг цэгийн үйлчилгээгээр 2 удаа 18 өрхийн 63 иргэнд нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн танилцуулга хийж, мэдээлэл хүргэн хууль сурталчлан ажилласан.



Хамралт, орлого, цахим үйлчилгээ хариуцсан байцаагч Н.Насанжаргал Нийслэлийн ерөнхий боловсролын "Хангай" сургуулийн төгсөх ангийн 63 суралцагчдад "Сайн дурын даатгал" сэдэвт сургалтыг зохион байгуулж мэдээлэл өгч ажиллалаа



Нийгмийн даатгалын хуулийг сурталчилсан шторкийг дүүргийн ЗДТГ-ын хэвлэл мэдээллээр дамжуулан дүүргийн иргэдэд, Нийгмийн даатгалын ерөнхий газраас цахим хуудсаараа дамжуулан хүргэж байгаа нийгмийн даатгалын хууль болон үйлчилгээтэй холбоотой 33 удаагийн видео бичлэгийг “Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар” пэйж хуудсаар, мөн албан хаагчид өөрсдийн фэйсбүүк хуудсаар шейрлэж нийгмийн даатгалын хуулийг сурталчилж байна.




Засаг даргын Нийгмийн бодлогын хөгжлийн орлогчоор ахлуулсан Засаг даргын Тамгын газар болон бусад харьяалах 10 хэлтэс албадын мэргэжилтнүүдийн хамт 2024 оны 4 дүгээр сарын 9,10-нд, 11 дүгээр сарын 6,7-ны өдрүүдэд дүүргийн шугам замын өртөө болон малчин өрхөд явуулын нэг цэгийн үйлчилгээгээр 4 удаа үйлчилж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн мэдээ, мэдээлэл өгч, нийт 30 өрхийн 97 иргэн хамрагдсан бөгөөд 9 иргэний тэтгэвэр тогтоолтын баримт бичгийг шалгаж, 5 өрхөд малчны сайн дурын даатгалын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, 5 төрлийн 160 гарын авлага тараан ажиллалаа.

Төмөр замын Хангай, Агуйт зөрлөг, Эрчим хүч, 12, 14-р өртөө зэрэг ажил олгогчдын ажлын байранд, малчин 9 өрхөд нийгмийн даатгалын хуулийн талаар мэдээлэл өгч 1 иргэнтэй сайн дурын даатгалын гэрээ байгуулсан.




Нийгмийн даатгалын ерөнхий газраас 9 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласантай холбогдуулан тус газар нь 2024 оны 9 дүгээр сарын 18,19-ний өдрүүдэд дүүргээс алслагдсан төмөр замын байгууллага болон малчин өрхүүдэд 3 байцаагч, мэргэжилтнүүд нийгмийн даатгалын үйлчилгээг ойртуулан ажлын байранд болон гэрт нь хүргэн ажиллаж, иргэд, даатгуулагчдаас өндөр насны малчнаар, хүнд нөхцлөөр тэтгэвэрт тогтоолгох, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт имонголиа цахим системд мэдээлэл харагдахгүй байгаа талаарх асуултанд байцаагч нар хариулт өгч мэдээллээр хангав.

Нээлттэй хаалганы өдөрлөг



Албан хаагчдын нийгмийн баталгаа, нийтийн арга хэмжээний талаар:

Хэлтсийн даргын 2023.05.17-ны өдөр “Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг А/17 дугаар тушаалаар 2 жилийн хугацаатай баталсан. Хөтөлбөрт тусгаснаар газрын гадна болон дотоод засварын ажлыг хийж албан хаагчдын ажиллах ая тухтай орчин бүрдүүлсэн.



Газрын даргын тушаалаар газрын 3 ахмад настанд “Сар шинэ”-ийн баяр, “Ахмадын өдөр”-өөр тус тус хүндэтгэл үзүүлж, 980000 төгрөгийг, мөн ердийн галлагаатай сууцанд амьдардаг 2 албан хаагчдад өвлийн улирлын түлш худалдан авахад зориулж тус бүр 230000 төгрөгийн нийт 460000 төгрөгийн дэмжлэг үзүүлэв.

2024 оны 11 сарын 18 өдөр Дугаар 578-9

Улаанбаатар хот

Нөхөж төлбөр олгох тухай

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗӨВСӨГӨӨ, НҮТЭГ ДЭВСГЭРИЙН НЭРХ, ТҮҮНИЙ УХИРЛАГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН 67 ДУГААР ХҮЙЛИЙН 67.6 ДАХЬ ХАСЛ, ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 16 ДУГААР ХҮЙЛИЙН 16.5.5 ДАХЬ ЗАСЛТ, ЗАСВИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ “ЭХҮРЭН БАЙЛАХ ТУХАЙ” 08 ДУГААР ТОГТООЛ, ГАЗРЫН ДОТООД ЗУВРАЙН 7.3.5 ДАХЬ ЗАСЛТУУЛАГ ТУС ТУС ҮНДЭСЛЭН ТУШААХ нь:

1. Байгууллагын ердийн галлагаатай сууцанд амьдардаг хамсартандаа дурдсан 2 ахмад насны өвчтөн өвлийн улирлын түлш худалдан авахад зориулж тус бүр 230 000 (хоёр зуун гурав мянган) төгрөгийн нөхөж төлбөр олгогдоггүй.



2. Нөхөж төлбөрт зарцуулагдах 460 000 (дөрвөн зуун зурван мянган) төгрөгийг ажир олгогчдоо олгох бүсэд татвар, урамшууллын хэргээр гаргахыг зогсоох нөхцөл боловч (Б.УДААЛ)-д зориулагдахгүй.

ДАРГА:  Б.БАЙЕТВРА

Мөн нийгмийн даатгалын 9 дүүрэг, агентлагийн хэмжээнд МУ-ын ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж байгаа гурван тулгуурт хөдөлгөөний нэг “Эрүүл монгол хүн- эко аялалын өдөрлөг”-ийг Багануур, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газартай хамтран зохион байгуулав.



Багахангай дүүргийн “Явган алхалтын холбоо”, Монголын “Явган алхалтын холбоо”-той хамтран 2024.11.22-ны өдөр 21 аймаг, 9 дүүргийн явган алхалтын холбоодын дунд “Адар баян” 100 км-ийн өвлийн явган алхалтанд газрын албан хаагчид оролцов.



Бүгд найрамдах улсаа тунхаглаж, анхдугаар үндсэн хуулиа баталсны 100 жилийн ойг тохиолдуулан дүүргийн ИТХ-аас зохион байгуулсан “Үндсэн хуулиа хэн сайн мэдэх вэ” АХА тэмцээнд тус газрын Сургалт сурталчилгаа, архив, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн Г.Отгончулуун оролцож тэргүүн байр эзэллэсэн.



УЛСАД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН АЛБА


ЭЭЖ ХӨГЖСӨНИЙ 113 ЖИЛҮЙН ОЙН
БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ

1991 1992 1993 1994 1995 1996 1997 1998 1999 2000 2001 2002 2003

+5.2% +6.9% +8.9% +7.1% +4.1%



АРХИВЧДЫН ӨДРИЙН БАЯРЫН МЭНД
 ХҮРГЭЕ





Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/18 дугаар тушаал, дүүргийн салбар зөвлөлийн төлөвлөгөөний хүрээнд “НЭРЭМЖИТ ТУГ” аялах хугацаанд Нийгмийн даатгалын газар 2024.11.21-11.28-ны хооронд дараах ажлуудыг зохион байгууллаа.

- Албан хаагчид дохионы хэлний анхан шатны мэдэгдэхүүний тухай судлаж, фэйсбүүк пэйж хуудсанд дохионы хэлний анхан шатны мэдэгдэхүүн олгох зурагт хуудсуудыг байршуулж, иргэд олон нийтэд түгээн ажиллав.
- Хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай 2 хүүхдэд тус бүр эрүүл мэндийн бүтээгдэхүүний дэмжлэг үзүүллээ.



ТАЙЛАН БИЧСЭН:
 СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, АРХИВ, ДОТООД АСУУДАЛ ХАРИУЦСАН
 МЭРГЭЖИЛТЭН *Г.Отгончулуун* Г.ОТГОНЧУЛУУН

ХЯНАСАН:
 ДАРГА



Б.БАЯРТУЯА